

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Огноо: 2020-01-28

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН “ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
МОБАЙЛ ТЕХНОЛОГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖХУДАЛДАН АВАХ АЖИЛ”
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр: *Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн мобайл технологийн тоног
төхөөрөмж худалдан авах ажил***
Төслийн дугаар: *ОНХСан/ХА-1*

**Эрдэнэ сум
2020 он**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020-01-28

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос *Эрүүл мэндийн төвийн мобайл технологийн тоног төхөөрөмж худалдан авах* ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээ болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөгөөр худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Төлбөрийн хийх хэлбэр: **Дансаар тушаана.**

Дансны нэр: **Эрдэнэ сум ЗДТГазар Төрийн сан банк**

Дансны дугаар № : **НС-100060455406**

Үнийн саналыг **2020 оны 02-р сарын 05-ний өдрийн 15 цаг 00 минутаас өмнө Эрдэнэ сумын Засаг даргын орлогчийн өрөөнд TENDER.GOV.MN цахим, Б.Буянбаатар /99892789, 96001452/ хаягаар ирүүлнэ.**

Үнийн саналын нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 02-р сарын 05-ний өдрийн 15 цаг 30 минутанд** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. **Үгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгийн газар, Засаг даргын орлогч Б.Буянбаатар, Хууль зүйн мэргэжилтэн, Утас 99892789, 96001452]

- 1. Эрх бүхий тендерт оролцогч** 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт** 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл** 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
- (a) *Үнийн санал;*
 - (б) *Оролцогч компанийн танилцуулга*
 - (в) *Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг; /санхүүгийн тайлан, туршилагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;*
 - (д) *Ижил төрлийн бараа, ажил үйлчилгээ үзүүлсэн туршилага Гэрээ, холбогдох тайлангийн хуулбар;*
 - (e) *Тусгай зөвшөөрөлийн баталгаажсан хуулбар хугацаа дуусаагүй тусгай зөвшөөрөл хүчинтэй байх.*
 - (ё) *Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар*
 - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл*
 - Харъяалагдах банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх*
 - Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх*
 - Гэрээг гүйцэтгэгч удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршилагын талаарх мэдээлэл*
 - Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршилагын мэдээлэл*
- 4. Тендерийн үнэ** 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон

тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН
ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [2] жилийн санхүүгийн тайлан 2018, 2019 оны /аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Сүүлийн [2] жилийн туршлагын мэдээлэл 2018, 2019 оны /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлцсэн актын хуулбар/;</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай: Үгүй</p> <p>Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар/ гэрээ болон хавсралтын хамт/</i> - <i>Оролцогч компанийн танилцуулга</i> - <i>Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</i> - <i>Харилцагч банкны тодорхойлолт тухайн ажилд хаяглагдсан байх /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</i> - <i>Татварын газрын тодорхойлолт тухайн ажилд хаяглагдсан байх /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</i> - <i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт тухайн ажилд хаяглагдсан байх /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</i> - <i>Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт тухайн ажилд хаяглагдсан байх /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</i> - <i>Гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл</i> - <i>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл</i>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: <i>Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазрын 6 тоот өрөө /TENDER.GOV.MN/ цахим хаяг</i> Огноо: <i>2020 оны 02 дүгээр сарын 05-ний өдөр</i> Цаг: <i>15 цаг 00 минут</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: <i>Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ЗДТГазар</i> Давхар болон өрөөний дугаар: <i>1 давхар 6 тоот өрөө</i> Огноо: <i>2020 оны 02 дүгээр сарын 05-ний өдөр</i> Цаг: <i>15 цаг 30 минут</i></p>
ТӨӨЗ 5.3 (в)	<p>Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: Машин механизм</p>

ТӨӨЗ 5.3 (г)	Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх жилийн тоо: 2 жил Түүний дотроос гэрээг хариуцаж ажилласан туршлагатай байх жилийн тоо: 2 жил
ТӨӨЗ 6.1	Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд: <i>Түншлэгч байгууллагууд гэрээнд гүйцэтгэх ажил үүргийн хуваарийг тодорхой зааж түншлэлийн гэрээнд заасан хуваарийн дагуу бараа, ажлыг хийж гүйцэтгэнэ.</i>
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Дорноговь аймгийн Эрдэнэ сумын “Эрүүл мэндийн төвийн мобайл технологийн тоног төхөөрөмж худалдан авах”-бараа, ОНХСан-ХА-2020/01, 1 багц бараанаас бүрдэнэ.
	Санхүүгийн эх үүсвэр: 2020 оны ОНХсангийн хөрөнгө оруулалтаар хийнэ. Жич: Өөрийн хөрөнгөөр ажлыг 100% гүйцэтгэж холбогдох байгууллагад хүлээлгэн өгснөөр санхүүжилтийг олгоно.
	Борлуулалтын хэмжээ: Жилийн борлуулалтын орлого дундажаар 80,0 сая
	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжит зээлийн хэмжээ: 10,0 сая
	Магадлашгүй ажлын зардал 2%-иар тооцож төсөвт тусгаж ирүүлэх.

**"МОБАЙЛ ТЕХНОЛОГИ"-ИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,
ОНОШЛУУРЫН ЗАХИАЛГА**

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

№	Шаардлагатай тоног төхөөрөмж, оношлуур	Үзүүлэлт /Дүйцэхүйц/	Тоо ширхэг
1	ЭХО /Мобайл /	Convex array 3.5 MHz/5MHz, Linear array 7MHz/10MHz,	1
2	ЭКГ /Мобайл /	Convex array 3.5 MHz/5MHz, Linear array 7MHz/10MHz, дүйцэхүйц	1
3	iPad таблет /Apple/ /эхо үзэх зориулалттай/	Apple iPad Wi-Fi (Wi-Fi, w/o GPS)	1
4	Нөтбүүк	<ul style="list-style-type: none"> • intel i5-8250U • DDR4 4GB 2400HZ • 1TB hard drive • 15.6" LED, HD 1366*768 GPU-R520-2GB дүйцэхүйц	1
5	Ланцет №100		5
6	ХДХВ/ДОХ-ын оношлуур		400
7	тэмбүүгийн оношлуур		400
8	хеликобактер илрүүлэх тест		300
9	Сахарын аппарат		1
10	Сахарын тест №50		5
13	Хавдрын ерөнхий маркер		100
14	элэгний хавдрын ерөнхий маркер		100
15	Бруцеллэзын оношлуур /50 хүн тун/		2
16	АСЛО, Ревматоид фактор, С урвалжийн уураг үзэх бодис		1

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймаг Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн мобайл технологийн тоног төхөөрөмж худалдан авах ажил:

Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, сертификатыг хавсаргана.

Хэрэв зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.

Гүйцэтгэсэн ажлыг ил далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

Дээрх техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу арга хэмжээ авах эрхтэй болно.

ЖИШИГ МАЯГТ
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
 2. **Төслийн менежерийн шийдвэр** 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
 3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх** 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
 4. **Аюулгүй байдал** 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
 5. **Зааварчилгаа** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
 6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
- Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
7. **Ажлын хөтөлбөр** 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
 8. **Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

- 9. Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас

хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

16. Эцсийн тооцоо

16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг
цуцалсан
үед хийх
төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээ
с чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСТАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>Дорноговь аймгийн Эрдэнэ сумын “Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн мобайл технологийн тоног төхөөрөмж худалдан авах”</i>
ГЕН 2.1	Ажил нь [<i>Дорноговь аймгийн Эрдэнэ сумын “Эрүүл мэндийн төвийн мобайл технологийн тоног төхөөрөмж худалдан авах”</i> бараа]-аас бүрдэнэ. Ажлын талбай нь сумын төв буюу Улаан-Уул багт байршина.
ГЕН 3.1	Төслийн менежер нь: <i>Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Алтанцацрал</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр 2020.02.12 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2020.03.12
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [<i>ажлын 6</i>] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа: 2 жил
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [<i>1 хувь</i>] байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [<i>10 хувь</i>] байна.
ГЕН 17.1	Гүйцэтгэлийн зургийг [<i>2020-03-25</i>]-ний дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [<i>500000 төгрөг</i>] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [<i>0 хувь</i>]-иар тооцно.

